

АВСТРАЛИ УЛСЫН “АЖИЛЛАХ БОЛОН АМРАХ” ВИЗ МЭДҮҮЛЭХ ИРГЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Австралийн нутаг дэвсгэрт хуанлийн арван хоёр (12) хүртэлх сарын хугацаанд амрах үндсэн зорилготой байх;
- Хамгийн багадаа арван найман (18) нас хүрсэн боловч виз мэдүүлэх үедээ гучин нэгэн (31) нас хүрээгүй байх;
- Асран хамгаалалтад нь байдаг хүүхэд хамт зорчихгүй байх;
- Хүчин төгөлдөр паспорт болон аяллын тийзтэй байх эсхүл, уг тийзийг худалдан авах санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байх;
- Австралийн нутаг дэвсгэрт ажиллах болон амрах зорилгоор хувийн хэрэгцээндээ зарцуулах санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байх;
- Австралийн хуульд заасан эрүүл мэндийн болон зан төлөвийн шаардлагыг хангасан байх;
- Австралийн “Ажиллах болон амрах” эсхүл, “Амралтаараа ажиллах” хөтөлбөрт урьд өмнө хамрагдаагүй байх;
- Дээд боловсролын гэрчилгээтэй эсхүл, их, дээд сургуульд хоёр (2)-оос доошгүй жил амжилттай суралцсан байх;
- Англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх (*Англи хэлээр сургалт явуулдаг бага болон дунд сургуульд 3 эсхүл 5 жил, эсхүл Англи хэлээр сургалт явуулдаг их, дээд сургуульд 1 жил суралцсаныг нотлох нотлох баримт бичиг, эсхүл IELTS, TOEFL iBT, PTE, CAE онооны сертификат*);
- Гадаад харилцааны яамнаас захидал авсан байх.